



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

дату 07.19 № 510
танай 2024.07.17 -ны № 01/62 -т

Г МАТАД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД
АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА УДАШ ТАНАА

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дорнод аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Дорнод аймгийн Ардчилсан намын Матад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлберийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр зургаан хуудас хавсаргав.

Хувийг: “Дорнод аймгийн Ардчилсан намын хороо”-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ




**ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН
АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БҮЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.07.17

Нэр: ШИНЭ СУМ

Уриа: “ЗОРИГТОЙ ӨӨРЧИЛЬЕ”

Зорилго: Улс, орон нутгийн эрх ашиг, хуулийг дээдлэн, хувь хүн, өрх гэр, сум, аймаг, бүсчилсэн хөгжлийг эрхэмлэж баялгийг бүтээгч иргэдийн амьдрах аюулгүй, ая тухтай амьдрах нөхцлийг хангах, дундаж орлоготой иргэдийг нэмэгдүүлж, Дорнодын шинэ бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.



Хэрэгжих хугацаа: 2024-2028

Зорилт:

- 1. ИРГЭНД ЭЭЛТЭЙ СУМ**
- 2. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ СУМ**
- 3. ХУУЛЬ ДЭЭДЭЛСЭН СУМ**
- 4. АЯ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ СУМ**
- 5. АЖИЛСАГ, БҮТЭЭЛЧ СУМ**
- 6. ТӨРИЙН БОДЛОГОТОЙ СУМ**

НЭГ. ИРГЭНД ЭЭЛТЭЙ СУМ

1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.
2. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
3. Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “эрүүл, чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах оюутны идэвхи, санаачилгыг дэмжиж ажиллана.
5. Сумдын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.
6. Газар эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг дэмжиж ажиллана.
7. Өмчийн эрхийг баталгаажуулж, хувийн өмчийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
8. Нийтийг хамарсан гамшигт өртөгчдөд үзүүлэх халамжийн тусламж, үйлчилгээг бий болгоно.
9. Бага орлоготой, ядуу өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулах, ажлын байранд зуучлах тогтолцоог бүрдүүлнэ.
10. Амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
11. “Боломж хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
12. Хашаандаа амины тохилог орон сууц барих санаачилгыг бодлогоор дэмжинэ.
13. Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
14. Өвлийн хүлэмжийн, мал, амьтны фермийн барилга байгууламжид хөрөнгө оруулах 15 хүртэлх жилийн моргэйжийн зээлийн хэлбэрийг нэвтрүүлж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.
15. Иргэдийн бодитой, үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулна.
16. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
17. Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод ажлын тайлангийн сонсгол хийх үүргийг хуульчлан баталгаажуулахыг дэмжиж ажиллана.
18. Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

ХОЁР. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ СУМ

1. Бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн орчныг шинэчлэхэд дэмжиж ажиллана.
2. Тариалангийн газрын хөрсний үржил шимиийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх тариаланчид болон төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэхийг дэмжиж ажиллана.
3. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгжээс авах ургацыг дээшлүүлнэ.
4. Тусгай хамгаалалттай газар нутгийг судалгааны үндсэн дээр нэмэгдүүлж, онцлог эко системийн үйлчилгээ, үнэ цэнийг өсгөнө.

- Газрын доорх усны нөөц баялгийг бүртгэлжүүлж, ашиглалтын зохистой менежмент явуулах, усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох зорилгоор гадаргын усны харуулын тоо болон газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлнэ.
- Ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хамгаалалтын зурvas байгуулах арга хэмжээг нэмэгдүүлнэ.
- Иргэдийн мод тарих санаачилгыг дэмжиж, бүртгэлийг цахимжуулан нийгмийн хөнгөлөлт эдлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхид суурилсан менежментийг нэвтрүүлнэ.

ГУРАВ. ХУУЛЬ ДЭЭДЭЛСЭН СУМ

- Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- Иргэний ба хуулийн этгээдийн хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн орчныг хэрэгжүүлнэ.
- Иргэний өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан, шийдвэрлэхгүй хугацаа хэтрүүлсэн төрийн албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэдэг болгоно.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг хэрэгжүүлэхийг дэмжиж ажиллана.
- Хууль дээдэлдэг захиргааг бүрдүүлэх, нийтийн албыг мэргэшүүлэх чиглэлд улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байна.
- Газрын төлөвлөлт, олголтын орчинд реформ хийж, газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.
- Иргэдийн өмчлөлийн газрын дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

ДӨРӨВ. АЯ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ СУМ

- Дотуур байрны орчин, нөхцлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран, тогтмол хэрэгжүүлнэ.
- Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.
- Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаа, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.
- Залуучуудын хөгжлийн “Community center” байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- Хичээллээс гадуурх сургалт, дугуйлангийн хамрагдалтыг дээшлүүлж, суралцагчийн сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөтгөнө.
- Багш, суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын цахим лаборатори, видео хичээл, е-сурах бичиг, онлайн сургалт, виртуал орчин бүхий сургалтын нээлттэй тогтолцоог дэмжинэ.
- Явуулын эмнэлгийн тоог нэмэгдүүлж чанаржуулахад анхаарч, өрх, сум, багийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үнэ, чанар, зохистой хэрэглээ, хүртээмжийн бодлогын хэрэгжилтийг шинэ түвшинд гаргана.

11. Хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулж, ясли, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх эрх зүйн орчныг бурдүүлнэ.
12. Нийтийн эзэмшлийн зам, талбай дахь камержуулалтын ажлыг суурилуулах журам, эрх зүйн баримт бичгийг боловсруулахад хувь хүний нууцыг хадгалахтай холбоотой асуудлыг анхаарна. “Манаачийг манах” буюу мэдээллийн дататай ажиллаж буй эрх бүхий албан тушаалтныг хянах технологийн шийдлийг нэвтрүүлнэ.
13. Хувь хүний орон байрны халдашгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох ажлыг дэмжинэ.
14. “Шүршүүр - жорлон” хөтөлбөрийг тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний дэлгүүрүүдэд санал болгож, хамтран хэрэгжүүлнэ.
15. гэр хорооллын дундах гудамжны өнгө төрхийг сайжруулан сэргээж, хайс, хашааг нэгдсэн байдлаар тохижуулна.
16. Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн “тохилог орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ТАВ. АЖИЛСАГ, БҮТЭЭЛЧ СУМ

1. “Өрх бүр баялаг бүтээгч” хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
2. Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн тогтмол орлого олох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
5. Ахмад настан чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. Гадаадад ажиллаж байгаа иргэдийн мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг эх орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
7. Орон нутгийн иргэдийн амьдралд эергээр нелөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
8. “Хариуцлагатай монгол хүн” хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрт дараах хариуцлагын үзүүлэлтүүдийг тусган хэрэгжүүлнэ.
 - Нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд, тухайлбал улс төрийн сонгуульд идэвхтэй оролцох, нийгмийн сайн сайхны төлөө ажиллах;
 - Байгаль орчинд ээлтэй хандах, жам ёсоор нь хадгалах, сэргээх, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, байгалийн нөөц, ялангуяа цэвэр усны нөөцдөд ариг гамтай хандагч байх;
 - Олон талын мэдээлэлд дүн шинжилгээ хийж чаддаг, бодит мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурласан дүгнэлт гаргах чадвартай байх;
 - Ардчилал, улс төр, засаглалын хөгжил, түүхийн мэдлэгээр өөрийгөө баяжуулах, насан туршдаа сурч боловсрох, иргэний боловсролоор өөрийгөө хөгжүүлэгч байх;
 - Ардчиллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх шатны сонгуульд саналаа өгөх, Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан саналаа илэрхийлдэг байх.
9. Шинээр бизнес эрхэлж буй иргэдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
10. Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацийн суурилсан дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
11. Хүн амыг орон сууцжуулах зорилтын хүрээнд дараах чиглэлээр орон сууцны бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:

- "Тогтвортой орлого бүхий орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймаг, сумын төвүүдэд орон сууцыг хүн амын зорилтот бүлэгт тааламжтай нөхцлөөр бүтээн байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ;
 - Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сумдын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, дэд бүтэцжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
12. Гүний болон гадаргуугийн усыг ариглан гамнах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
13. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд сум бүрт 50 га ногоон байгууламж бий болгохыг дэмжиж ажиллана.
14. Айл өрхийг хосолмол эх үүсвэртэй болгож, илүү үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг сүлжээнд нийлүүлдэг "өрх бүр эрчим хүч үйлдвэрлэгч" болохыг дэмжинэ.
15. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн бизнес эрхлэхэд чиглэсэн хувийн хэвшлийн санаачилгыг урамшуулан дэмжиж, малын таримал тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.
16. Өндөр ашиг шимтэй үндэсний болон дасан зохицох чадвартай гадаадын үржлийн малыг өсгөн бойжуулах үржлийн аж ахуйг хөгжүүлж, малчдад чанартай, таваарлаг малтай болох боломжийг бүрдүүлнэ.
17. Эрсдэл бүхий нөхцөлөөс урьдчилан сэргийлэх тохиолдол бий болсон үед малчдад худалдан борлуулж, эргэлтэд оруулах зорилготой өвс, тэжээлийн нөөцийн фондын тогтолцоог бий болгоно.
18. Хүлэмжийн аж ахуй, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ. Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, шинэ ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулна.
19. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг үргэлжлүүлж, бүх сумдыг хамруулах ажлыг үе шаттай эхлүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэц, цэвэр эрчим хүчний технологид оруулах хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
 - Сумдын цахилгаан эрчим хүчний дэд станцуудыг өргөтгөх, цахилгаан дамжуулах агаарын шугамуудын насжилтгыг тодорхойлж, өргөтгөн шинэчилнэ.
 - Суманд мах хөргөлтийн агуулах зоорь, сумдад малын түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.
20. Гэр хорооплын Цахилгаан шугам сүлжээний дэд станцуудыг судалгаанд үндэслэж өргөтгөнө.

ЗУРГАА. ТӨРИЙН БОДЛОГОТОЙ СУМ

1. Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
2. Гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгох "Монгол гэр бүл" боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин "малжуулах хөтөлбөр"-ийг орон даяар хэрэгжүүлнэ.
4. Газар тариалангийн бус нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
5. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. Малын эмч нарын ур чадварыг дэмжих замаар нэгж малд ногдох мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
7. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.
8. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
9. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн бодлого, сонгон шалгаруулалт, урамшуулал, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинээр бүрдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг үйлчлүүлэгчдийн оролцоотой, ил тод, шударга болгоно.
10. Өрх, сумын эрүүл мэндийн төвд ажиллах эмчийг бодлогоор дэмжиж, тоог нэмэгдүүлнэ.

11. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоог бий болгох, олон улсын стандартыг нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
12. Малаас гарч буй түүхий эд, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн төвүүдийг бодлогоор дэмжинэ.
13. Аймаг, сум хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг чөлөөт өрсөлдөөнд шилжүүлж, дагаж мөрдөх стандартыг сайжруулна.
14. Суурь хэрэгцээний хүнсийг үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийн санал, санаачилгыг дэмжинэ.
15. Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
16. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн, өгөөжтэй санхүүгийн зуучалыг хөгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг ашигласнаар иргэн, аж ахуйн нэгжид бий болох ашгийн бодит хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.
17. Нийгмийн халамжийн хөтөлбөрт үр нөлөөний үнэлгээ хийж, халамжид хамрагдах шалгуур, нөхцөлийг оновчтой болгоно.
18. Нийгмийн халамжийн нийтлэг мөнгөн тэтгэмж, тусlamжийн төрлийг цөөлж, ядуу, зорилтот өрх, иргэнд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
19. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн халамжийн хөтөлбөрүүдийг төгсөх хугацаатай болгоно. Халамжийн хөтөлбөрөөр дамжуулан хөдөлмөр эрхлэх сэдлийг бий болгож, шаардлагатай тохиолдолд хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх, өрх, иргэнийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.
20. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг баг, сумын түвшинд тодорхой зорилт, шалгуур үзүүлэлтээр гаргаж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулна.
21. Бага орлоготой, ядуу айл өрхүүдэд зориулсан хүнсний хангамжийн хөтөлбөр хэрэгжүүлж, шим тэжээлийн дутагдлаас хамгаална.
22. Байгалийн гамшиг, үер, зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авах арга хэмжээний талаарх халамжийн хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.
23. Нүүдлийн ахуйд суралцах, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг дэмжинэ.
24. Биет бус соёлын өвийг бүртгэж, хадгалах
25. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг бодлогоор дэмжинэ
26. Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.
27. Ноос боловсруулах үйлдвэрийг сэргээж, ноосон эдлэл, бүтээгдэхүүн, ялангуяа шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортлоход ажил дэмжлэг үзүүлнэ.
28. "Хариуцлагатай, чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
29. Max, сүү, шувуу, зэгийний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ. Хот, аймгийн төв, томоохон суурин газрын хүнсний хангамжийг сайжруулж, үнийг тогтвржуулна.
30. Малын гаралтай хоёр дахь түүхий эдийг хаягдалгүй боловсруулах, өндөр уургийн агууламжтай түүхий эд үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.